



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/04

Ховд

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг олгох, сунгах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, 19.3.2, 19.17.1, 19.17.2 дахь заалтууд, аймгийн Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх “Эммед партнер-2” эмнэлэгийг 3 жилээр, “Ивээл” уламжлалт анагаах ухааны эмнэлэг, 2 дугаар зэрэглэлийн “Мөст Цамбагаравын Ачтан” эмийн сангуудыг тус тус 1 жилийн хугацаатайгаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хугацаа нь дуусч үргэлжлүүлэн ажиллах нөхцөл шаардлагыг хангасан нь комиссын дүгнэлтээр тогтоогдсон “Алтан гагнуур” эмийн сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 5 жил, 2 дугаар зэрэглэлийн үйл ажиллагаа явуулах “Тунгалаг тун” эмийн сангийн тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жил, Ариутгал халдваргүйтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй “Ноён худагт” нөхөрлөлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилээр тус тус сунгасугай.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгосон болон сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, оношлогоо эмчилгээний тусламж үйлчилгээний шинэ техник, технологи, шинэ төрөл, бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжиж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын дарга /Д.Оюунцэцэг/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 00020